



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СҮМҮН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 29 өдөр

Дугаар A/21

Хужирт сум

“Цагаан сарын баяр”-ыг тэмдэглэн
өнгөрүүлэхийг хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.8 “а”, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, аймгийн Засаг даргын 2021 оны “Цагаан сарын баяр”-ыг аймгийн хэмжээнд тэмдэглэхийг хориглох тухай” А/35 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын хэмжээнд Коронавируст цар тахлын тархалт буурахгүй байгаа, халдварт аймагт зөөвөрлөгдөн орж ирэх эрсдлээс урьдчилан сэргийлэх, нийт ард, иргэдийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор аймгийн хэмжээнд цагаан сарын баярыг тэмдэглэхийг хориглосонтой холбоотойгоор 17 дугаар жарны цагаагчин үхэр жилийн “Цагаан сарын баяр”-ыг сумын хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлэхийг хориглосугай.

2. Шашны байгууллагын шашин номын хурал, цуглаан зохион байгуулах, зан үйлд олон нийтийг оролцуулахгүй байхыг Ганданоривлон хийдийн ловон лам (Н.Батзаяа)-д даалгасугай.

3. Цагаан сарын баярыг тэмдэглэхгүй байх, аймаг, сум, баг дамжин золголт хийхгүй, иргэдийн бөөгнөрөл үүсгэхгүй байхыг олон нийтэд өргөн далайцтай сурталчлахыг Засаг даргын газрын дарга (З.Цэцэгмаа), багийн Засаг дарга нар, байгууллага, аж ахуйн нэгжийн дарга, захирал нарт тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Онцгой комиссын орлогч дарга (Б.Дэмбэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Т.БАЯРМӨНХ

250100041